



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/87

Алтрага

Сонгон шалгаруулах үнэлгээний хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих "Эмт багийн Дэлгэрмөрөн гол дагуух 4 цэгт зам даваа засах" 6,000,000 (зургаан сая) төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Л.Чимэдцэрэн (Засаг даргын орлогч)
Гишүүд:	Б.Мөнхбат (Бэлтэс 5 дугаар багийн Засаг дарга)
Нарийн бичгийн дарга:	З.Наранцэцэг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

2.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих "Эмт багийн Дэлгэрмөрөн гол дагуух 4 цэгт зам даваа засах" ажлыг хууль журмын хүрээнд зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Л.Чимэдцэрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010200